



Тандэм Инвэст ББСБ
Хувьцаат компани *tanggem*

2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК

УЛААНБААТАР ХОТ, 2025 ОН

ТАНД ДЭМ

"Тандэм Инвэст ББСБ" ХК-ийн 2024 оны
үйл ажиллагааны тайлан

Агуулга

КОМПАНИЙН ТУХАЙ

- 04 Компанийн ерөнхий мэдээлэл
- 05 Гүйцэтгэх удирдлагын баг
- 05 Компанийн ажилчид, сургалт
- 06 Хувьцаа эзэмшлийн байдал
- 07 Компани нийгмийн хариуцлагын хүрээнд
- 07 Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 08 Компанийн үйл ажиллагаа
- 09 Зээлийн үйл ажиллагаа
- 10 Ногдол ашгийн бодлого

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

- 12 Компанийн санхүүгийн байдал
- 12 Компанийн нийт активын бүтэц
- 13 Компанийн ашигт ажиллагаа, өгөөжийн үзүүлэлт

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- 14 Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны төлөвлөгөө
- 16 ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл, хурлын ирц
- 17 ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

"Тандем Инвэст ББСБ" ХК-ийн 2024 оны
үйл ажиллагааны тайлан

КОМПАНИЙН ТУХАЙ

Компанийн ерөнхий мэдээлэл

Компанийн нэр	Тандем Инвэст ББСБ ХК
Компанийн хэлбэр	Нээлттэй хувьцаат компани
Монголын хөрөнгийн бирж дээрх бүртгэл, симбол нэр	II-р ангилал, MSE:TAND
Регистрийн дугаар	2013916
Улсын бүртгэлийн дугаар	9010001130
Тусгай зөвшөөрлийн дугаар	T3101/214
Үүсгэн байгуулагдсан огноо	1996 оны 4-р сарын 30-ны өдөр
Гүйцэтгэх захирал	Батжаргал овогтой Бадамцэцэг
Үйл ажиллагааны чиглэл	Зээлийн үйл ажиллагаа Гадаад валютын арилжаа Итгэлцлийн үйлчилгээ
Хувьцаа эзэмшигчдийн тоо	950
Гаргасан хувьцааны төрөл тоо ширхэг	2,000,000,000 ширхэг энгийн хувьцаа
Хувьцааны нэрлэсэн үнэ	2.30 төгрөг
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	4,600,000,000 төгрөг
Албан ёсны хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 2-р хороо, Эрхи төв, 402 тоот
Холбогдох утас	70151510
Цахим шуудан	info@tandem.mn
Цахим хаяг	www.tandem.mn

Гүйцэтгэх удирдлагын баг

Овог нэр	Мэргэжил	Албан тушаал
Б.Бадамцэцэг	Эрх зүйч	Гүйцэтгэх захирал
Б.Болормаа	Банкны менежмент	Санхүү, бүртгэл хариуцсан захирал
Ж.Батбилэг	Эдийн засагч	Комплаенс, дотоод хяналт
Ц.Билэг-Өрнөх	Санхүү менежер	Үйл ажиллагаа хариуцсан захирал
Б.Уянга	Банкны эдийн засагч	Бизнес хөгжил хариуцсан захирал

Компанийн ажилчид, сургалт

Компани ажилчдынхаа суралцах, өсөж хөгжих эрмэлзлийг идэвхтэй дэмжин, ажиллангаа сурах, мэдлэг ур чадвараа тогтмол нэмэгдүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд 4 ажилтанд 100 хувь сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн байна.

Мөн ажилтнуудынхаа эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор хуулийн фирмтэй хамтран сургалт зохион байгуулсан.



Санхүүгийн мэдээллийн албанаас хууль сахиулах байгууллагуудтай хамтран банкнаас бусад салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдэд сургалт зохион байгуулсан бөгөөд тус сургалтад компанийн 3 ажилтан, мөн тогтвортой санхүүжилт, ногоон хөгжил сэдэвт сургалтад 1 ажилтныг хамруулсан.

Тус сургалтаар сургалтаас авсан мэдээ, мэдээлэл, заавар зөвлөмжийг компанийн ажилчдад таниулан хүргэхээр 2024 оны 12-р сарын 3-ны өдөр сургалт зохион байгуулсан.



Ажилчдын чөлөөт цагт амралт, спортын арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд гүйцэтгэх удирдлагын зүгээс эрүүл мэнд, спортын арга хэмжээнд тодорхой хэмжээний төсвийг тогтоон баталсан байна.







Тандэм Инвэст ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшлийн байдал

Компанийн 2024 оны 3-р сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолоор хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах шийдвэр гарсны дагуу 491,883,292 ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргаснаар хувьцаа эзэмшлийн байдалд өөрчлөлт орсон. /Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 сарын 25-ны өдрийн 306 тоот тогтоолоор хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргахыг зөвшөөрсөн шийдвэр гарсан/

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 5,000,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаатай ба үүнээс 2,000,000,000 ширхэг гаргасан энгийн хувьцаатай бөгөөд нийт 950 хувьцаа эзэмшигчидтэй байна. Компанийн 950 хувьцаа эзэмшигчдээс тав буюу түүнээс дээш хувь эзэмшигч дотоодын 1, гадаадын 2 иргэн байна. Таваас дээш хувь эзэмшигчдийн хувьцаа компанийн гаргасан нийт хувьцааны 99.4% байгаа ба үлдсэн 0.6%-ыг бусад 947 хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

Овог нэр	Иргэншил	Хувьцааны Тоо /ш/	Хувьцааны Эзлэх хувь /%/
Ш.Такаёши	Япон	1,005,223,695	50.26%
Ч.Чинзориг	Монгол	680,801,414	34.04%
Ш.Михоко	Япон	301,649,958	15.08%
Бусад 954 хувьцаа эзэмшигч	Олон нийт	12,320,343	0.6%



Компани нийгмийн хариуцлагын хүрээнд



Инновацын эзэд

Монгол улсын ирээдүй болсон хүүхэд залуусын шинжлэх ухаан, технологи, инженерчлэлийн авьяас чадварыг багаас нь нээн илрүүлж хөгжүүлэх, технологи, инженерчлэлийн чиглэлийн сонирхол хоббиг өдөөх, сэдэлжүүлэх үндсэн зорилго бүхий "Инновацын Эрэлд" контентын төслийг хоёр жил дараалан ивээн тэтгэн хамтран ажиллаж байна.


Happy Tooth Project

Монгол улсын иргэдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зорилготой Монгол Японы хамтарсан (HAPPY TOOTH PROJECT) төсөлд хоёр жил дараалан ивээн тэтгэн хамтран ажиллаж байгаа.

Мод тарих

Компани нийгмийн хариуцлагын хүрээнд "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-д нэгдэж Завхан аймгийн Сонгино суманд 200 мод тарьсан.

Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө




БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн үйл ажиллагаа

Компани 2024 оны байдлаар зээлийн үйл ажиллагаа, гадаад валютын үйл ажиллагаа, итгэлцлийн үйлчилгээ гэсэн 3 чиглэлээр нийт 14 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 4-р сарын 23-ны өдрийн хурлаар компанийн салбар нэгжийг байгуулахаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу компанийн салбар нэгжийг Сонгинохайрхан дүүрэгт “Цамба салбар” нэртэйгээр байгуулсан.



Зээлийн үйл ажиллагаа

Компани уламжлалт аргад суурилсан доорх зээлийн дөрвөн бүтээгдэхүүнээр дамжуулан зээлийн үйлчилгээг харилцагчдад үзүүлж байна.

Тээврийн хэрэгсэл худалдан авах зээл	Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл	Хэрэглээний зээл	Цалингийн зээл
Зээлийн хэмжээ: 200 сая төгрөг хүртэл	Зээлийн хэмжээ: 700 сая төгрөг хүртэл	Зээлийн хэмжээ: 50 сая төгрөг хүртэл	Зээлийн хэмжээ: 10 сая төгрөг хүртэл
Зээлийн хүү: 2.5%	Зээлийн хүү: 2.5%	Зээлийн хүү: 3%	Зээлийн хүү: 1.8%
Зээлийн хугацаа: 12-48 сар хүртэл	Зээлийн хугацаа: 48 сар хүртэл	Зээлийн хугацаа: 12 сар хүртэл	Зээлийн хугацаа: 24 сар хүртэл
Зээлийн урьдчилгаа/шинэ: 30%	Зээлийн урьдчилгаа/шинэ: 30%	Зээлийн урьдчилгаа/шинэ: 30%	Зээлийн урьдчилгаа/шинэ: 30%
Барьцааны үнэлгээ/хуучин: 60% хүртэл	Барьцааны үнэлгээ/хуучин: 60% хүртэл	Барьцааны үнэлгээ/хуучин: 60% хүртэл	Барьцааны үнэлгээ/хуучин: 60% хүртэл

Компанийн нийт зээлийн багц 2024 оны 4-р улирлын эцсийн байдлаар 26.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд энэ онд нэмэлт хөрөнгө татсантай холбогдуулан жилийн эцсийн байдлаар нийт зээлийн багцын хэмжээ өмнөх онуудаас өссөн дүнтэй байна.



Компанийн зээлийн багцыг зориулалтаар авч үзвэл 71.57% автомашин худалдан авахад зориулсан зээл, 2.40%-ийг ЖДҮ, бизнесийн үйл ажиллагаанд зориулсан зээл, 22.52%-ийг үл хөдлөх эд хөрөнгө худалдан авахад зориулсан зээл, 0.51%-ийг хэрэглээнд зориулсан зээл тус тус эзэлж байна.

Зээлийн багцын чанарын хувьд 2024 оны 4-р улирлын эцсийн байдлаар 87.89 %-ийг хэвийн зээл, 4.79%-ийг хугацаа хэтэрсэн зээл, 7.31%-ийг чанаргүй зээл эзэлж байна.



Компанийн олгосон зээлийн хэмжээ 2021 онд 8 тэрбум төгрөг, 2022 онд 19.3 тэрбум төгрөг, 2023 онд 14.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд 2024 оны 4-р улирлын байдлаар 24.5 тэрбум төгрөг байна.



Мөн олгосон зээлийн тоо 2021 онд 495, 2022 онд 864, 2023 онд 683, 2024 оны 4-р улирлын байдлаар 769 удаагийн зээл олгосон байна.

Ногдол ашгийн бодлого

Компани 2023 оны үйл ажиллагааны цэвэр ашгаасаа 3.3 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд 2024 онд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан хуваарилсан.



“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛНА

"Тандэм инвест ББСБ" ХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, "Тандэм Инвэст ББСБ" ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.10 дахь заалт, Ногдол ашгийн журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолоор 2024 оны үйл ажиллагааны цэвэр ашиг болох 3,705,620,626.44 төгрөгөөс компанийн хувьцаа эзэмшигчдэд 2,200,000,000 төгрөгийг, нэгж хувьцаанд ногдох хэмжээг 1,10 (нэг төгрөг арван мөнгө) төгрөгөөр тооцон хуваарилахаар шийдвэрлэжээ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Компанийн санхүүгийн байдал


Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, нэмэлт тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлт гаргасан.

Дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /"СТОУС"/-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Балансын зүйл	2021	2022	2023	2024
Эргэлтийн хөрөнгө	6,946,220,250.00	17,533,629,359.00	20,596,490,525.00	30,229,570,043.00
Эргэлтийн бус хөрөнгө	46,321,074.00	488,384,829.00	444,348,917.00	771,518,747.00
Нийт хөрөнгө	6,992,541,324.00	18,022,014,188.00	21,040,839,442.00	31,001,088,790.00
Өр төлбөр	1,120,637,386.00	3,765,578,003.00	5,471,305,393.00	5,385,860,896.00
Энгийн хувьцаа	2,601,501,321.00	3,468,668,428.00	3,468,668,428.00	4,600,000,000.00
Халаасны хувьцаа	-3,569,520.00	-3,569,520.00	-3,569,520.00	-3,569,520.00
Нэмж төлөгдсөн капитал	2,294,210,877.00	8,779,112,743.00	8,779,112,743.00	17,288,693,694.00
Хуримтлагдсан ашиг / алдагдал/	979,761,260.00	2,012,224,534.00	3,325,322,398.00	3,730,103,720.00
Эздийн өмч	5,871,903,939.00	14,256,436,185.00	15,569,534,049.00	25,615,227,894.00
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	6,992,541,324.00	18,022,014,188.00	21,040,839,442.00	31,001,088,790.00

Компанийн нийт активын бүтэц

Компанийн нийт хөрөнгө 2024 оны 4-р улирлын байдлаар 31 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 47% буюу 9.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт активын бүтцийг эх үүсвэрээр нь хуваан харвал 5.3 тэрбум төгрөгийн өр төлбөр, 25.6 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгө байгаа бөгөөд өөрийн хөрөнгийн харьцаа 82.63% -тай байна.



Компанийн ашигт ажиллагаа, өгөөжийн үзүүлэлт

Компанийн 2024 оны жилийн эцсийн байдлаарх нийт орлого 6.3 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 16.48%-аар өссөн байна. Харин цэвэр ашиг нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 3.7 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 12.17%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Компанийн нийт орлогыг задалж үзвэл 2024 оны жилийн эцсийн байдлаар цэвэр хүүгийн орлого 6.3 тэрбум төгрөг буюу 96.8%-ийг эзэлж байгаа бөгөөд хүүгийн бус орлого 363,696,319 сая буюу 3.2%-ийг эзэлж байна.



Компанийн нийт хөрөнгийн өгөөж 2024 оны жилийн эцсийн байдлаар 14.2%-д хүрсэн бөгөөд өөрийн хөрөнгийн өгөөж 18.0%-д хүрч өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Компанийн цэвэр ашгийн хувь 2024 оны жилийн эцсийн байдлаар 12.17% байна.



"Тандэм Инвэст ББСБ" ХК-ийн 2024 оны
үйл ажиллагааны тайлан

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны төлөвлөгөө

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 03 тоот тогтоолоор 3 жилийн хугацаатай томилсон.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлж, компанийн тухай хуульд заасан бусад эрх үүргийн дагуу гүйцэтгэх удирдлагад компанийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдахад шаардлагатай асуудлуудад шийдвэр гарган чиглэлийг өгч ажилласан.

Тайлант хугацаанд төлөөлөн удирдах зөвлөл нь 15 удаа хуралдаж, нийт 25 тогтоол гарсан байна. Компанийн ТУЗ нь компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т заасныг хэрэгжүүлэн 6 хараат, 3 хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн засаглалын кодексийн зөвлөмжөөр компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шинээр сонгогдох ТУЗ-ийн гишүүдийн олонхыг хараат бус байх зөвлөмжийг хангахаар эрмэлзэн ажиллаж байна.

ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга гишүүдийн жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ

2024 оны 3-р сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-д үүрэг болгосон ажлуудыг амжилттай гүйцэтгэсэн байна.

1. Тайлант хугацаанд 950 хувьцаа эзэмшигчдэд 2,869,277,253.13 төгрөгийн ногдол ашиг хуваарилсан,
2. Хаалттай хүрээнд нэмэлт үнэт цаас гарган 9.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татсан,
3. Хаалттай хүрээнд нэмэлт үнэт цаас гаргахтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн эргүүлэн авахыг шаардах эрхийг хэрэгжүүлсэн,
4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, зарласан хувьцаанд өөрчлөлт орсноор компанийн дүрэм шинэчлэгдсэн бөгөөд дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

5. Мөн компанийн 2022 оны 8-р сарын 13-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 11 тоот тогтоолын хэрэгжилтийг хангаж компанийн салбар нэгжийг Сонгинохайрхан дүүрэгт байгуулсан.

6. Компанийн гүйцэтгэх захирал Ж.Ганхүлэг өөрийн хүсэлтээр ажлаас гарсантай холбогдуулан компанийн гүйцэтгэх захирлыг чөлөөлж, шинээр Б.Бадамцэцэгийг томилсон

Компанийн үйл ажиллагаатай холбогдуулан компанийн зээлийн үйл ажиллагааны нөхцөлд өөрчлөлт оруулсан гэх мэт асуудлуудыг шийдвэрлэж гүйцэтгэсэн бөгөөд ТУЗ-ийн хуралд гишүүд 100 хувь оролцсон байна.

2025 оны төлөвлөгөө

01. ТУЗ-ийн гишүүдэд зориулсан сургалт

ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2025 онд дуусаж байгаа бөгөөд Компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дахин сонгож, шинээр сонгогдож байгаа ТУЗ-ийн гишүүдэд чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтын төлөвлөгөөг хавсралтад тусгасан бөгөөд тус оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулан шийдвэрлүүлэхээр төлөвлөж байна.

02. ТУЗ-ийн дэргэдэх хороодыг томилох

Компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар ТУЗ-ийн хороодын даргаар хараат бус гишүүн томилж компанийн засаглалаа сайжруулахаар төлөвлөж байна.
/Эрсдэлийн хороо нэмж байгуулах

03. Ил тод байдал, мэдээ мэдээлэл

Жил бүрийн үйл ажиллагааны тайланг компанийн цахим хуудсанд байршуулж Хувьцаа эзэмшигчдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллах

ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл, хурлын ирц

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



Ч.ЧИНЗОРИГ

ТУЗ-ийн ДАРГА
МЭРГЭЖИЛ: ЭДИЙН ЗАСАГЧ,
БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, КОМПАНИ ЗАСАГЛАЛ



Ц.БИЛЭГ-ӨРНӨХ

ТУЗ-ийн ГИШҮҮН
МЭРГЭЖИЛ: САНХҮҮЧ,
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ



Л.ОЧИРМАА

ТУЗ-ийн ГИШҮҮН
МЭРГЭЖИЛ: ИНЖЕНЕР, МЭДЭЭЛЛИЙН
СИСТЕМИЙН УДИРДЛАГА



П.ЧИНЗОРИГ

ТУЗ-ийн ГИШҮҮН
МЭРГЭЖИЛ: ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА



Ч.БАДМААРАГ

ТУЗ-ийн ГИШҮҮН
МЭРГЭЖИЛ: СУДЛААЧ, ТҮҮХЧ



Ч.ТЭМҮДЭР

ТУЗ-ийн ГИШҮҮН
МЭРГЭЖИЛ: ЭДИЙН ЗАСАГЧ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Б.ЭНХ-АМГАЛАН

ТУЗ-ийн ХАРААТ БУС
ГИШҮҮН
МЭРГЭЖИЛ: ЭДИЙН ЗАСАГЧ-
СТАТИСТИКЧ



Ч.ЛОДОЙРАВСАЛ

ТУЗ-ийн ХАРААТ БУС ГИШҮҮН
МЭРГЭЖИЛ: ИНЖЕНЕР, ФИЗИК
ЭЛЕКТРОНИК



А.ДАВААЗОРИГ

ТУЗ-ийн ХАРААТ БУС
ГИШҮҮН
МЭРГЭЖИЛ: УРЛАГ СУДЛААЧ,
ХӨГЖИМЧИН

ТУЗ-ийн гишүүдийн хурлын ирц

Нэрс	Хурлын ирц	Мэдээлэл	Хувьцаа эзэмшигч эсэх
Ч.Чинзориг	100 хувь	ТУЗ-ийн дарга	Тийм
Ч.Лодойравсал	100 хувь	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Үгүй
Б.Энх-Амгалан	100 хувь	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Үгүй
А.Даваазориг	100 хувь	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Үгүй
Ц.Билэг-Өрнөх	100 хувь	ТУЗ-ийн гишүүн	Тийм
Ч.Тэмүдэр	100 хувь	ТУЗ-ийн гишүүн	Тийм
П.Чинзориг	100 хувь	ТУЗ-ийн гишүүн	Тийм
Л.Очирмаа	100 хувь	ТУЗ-ийн гишүүн	Тийм
Ч.Бадмаараг	100 хувь	ТУЗ-ийн гишүүн	Тийм

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа



Эрсдэл, Аудитын хороо

1. Б.Энх-Амгалан
2. Ц.Билэг-Өрнөх
3. Ч.Лодойравсал



Цалин урамшууллын хороо

1. Ц.Билэг-Өрнөх
2. Ч.Лодойравсал
3. А.Даваазориг



Нэр дэвшүүлэх хороо

1. П.Чинзориг
2. А.Даваазориг
3. Б.Энх-Амгалан

Эрсдэлийн хороо нь компанийн гадаад болон дотоод эрсдэлийг үнэлэн, комплаенсын хяналтын хэрэгжилтэд хяналт тавин ТУЗ-д танилцуулан ажилласан. Аудитын хороо нь дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг тухай бүр гүйцэтгэх захиралд өгч ажилласан. Мөн компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж, зөвлөмж өгч ажилласан байна.

Тайлант хугацаанд ТУЗ болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалингийн хэмжээнд өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн байна. Мөн компанийн гүйцэтгэх захирлын цалинг 3,227,600 төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд хороо хуралдаагүй байна.



“ТАНДЭМ ИНВЭСТ
ББСБ” ХК

ТАНД ДЭМ

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК



70151510



info@tandem.mn



www.tandem.mn



Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол
дүүрэг 2-р хороо, Эрхи төв, 402 тоот

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 3 сарын 20 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 64 дүгээр зүйлийн 64.2, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт компанийн ажлын байранд хуралдуулсугай.
2. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
 1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
 2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 3. “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ тогтоолыг танилцуулах;
 4. Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах;
 5. ТУЗ гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох тухай;
 6. Өрийн бичиг гаргах тухай хэлэлцэн батлах;
 7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах;
 8. Компанийн шинэчилсэн дүрмийг батлах;
 9. Бусад
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 10-ний өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт №1-ээр “Хурлын дэг”-ийг Хавсралт №2-оор, хувьцаа эзэмшигчдээс авах “Саналын хуудас 1”-ийг Хавсралт №3-аар, “Саналын хуудас 2”-ыг Хавсралт №4-өөр, “Хурлын зар”-ыг Хавсралт №5-аар тус тус баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахтай холбогдуулан доорх бичиг баримттай 2025 оны 4 дүгээр сарын 24-ны өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цаг хүртэл компанийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурдсугай. Үүнд:
 1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол болон тус тогтоолд холбогдох хавсралтуудын хуулбарууд,
 2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн хуулбар
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт 2025 оны 3 дугаар сарын 25-ний дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын

Хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэх, Хавсралт №5-ын дагуу хурлын зарыг 2025 оны 3 дугаар сарын 29-ний дотор өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д цахим хуудсаар тус тус дамжуулан нийтэд мэдээлэх, 2025 оны 3 дугаар сарын 30-ны дотор брокер дилерийн компанид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бадамцэцэгт даалгасугай.

7. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.
8. Компанийн ээлжит хурлыг удирдан зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн дарга Ч.Чинзориг, комиссын гишүүнээр Ч.Тэмүдэр, хурлын нарийн бичгийн даргаар Б.Бадамцэцэг нарыг тус тус томилсугай.
9. Хурлын тооллогын комиссын даргаар В.Шинэбаяр, тооллогын комиссын гишүүнээр Ж.Батбилэг, Ц.Сарангуа нарыг тус тус томилсугай.
10. Хурлын бэлтгэлийг хууль, журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ


Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн
5 тоот тогтоолын Хавсралт №1



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК
Хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Эрхи төв 402 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2025 оны 4 сарын 30 өдөр 10:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Компанийн ажилын байранд, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Эрхи төв 402 тоот /танхимаар/
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2025 оны 3 сарын 20 өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2025 оны 3 сарын 25 өдөр
Бүртгэлийн өдөр:	2025 оны 4 сарын 10 өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2025 оны 3 сарын 27 өдөр /Цахимаар/
Хүргүүлсэн огноо:	2025 оны 3 сарын 24 өдөр
Саналын хуудас хүлээн авах сүүлийн өдөр	2025 оны 4 сарын 29 өдөр 17 цаг хүртэл
Хурлын даргын нэр:	Ч.Чинзориг
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	В.Шинэбаяр, Ж.Батбилэг, Ц.Сарангуа
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт бичгийн хуудасны тоо:	ширхэг ...
	хуудас ...

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА



/Ч.Чинзориг /

2025 оны 3 сарын 20 өдөр

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн
5 тоот тогтоолын Хавсралт №2



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1	Бүртгэлийн үйл ажиллагаа	10 минут	Тооллогын комисс
2	Хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах	5 минут	Хурлын дарга
3	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;	5 минут	Хурлын дарга
4	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;	5 минут	Аудитын хорооны дарга
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын “Ногдол ашиг хуваарилах тухай” 3 тоот тогтоолыг танилцуулах;	5 минут	Хурлын дарга
6	Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах;	10 минут	Хурлын дарга
7	ТУЗ гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох;	10 минут	Хурлын дарга
8	Өрийн бичиг гаргах тухай хэлэлцэн батлах;	15 минут	Хурлын дарга
9	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах;	10 минут	Хурлын дарга
10	Компанийн шинэчилсэн дүрмийг батлах;	5 минут	Хурлын дарга
11	Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт	20 минут	Хурлын дарга
12	Саналын хуудсаар санал авах	10 минут	Тооллогын комисс
13	Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх	30 минут	Тооллогын комисс
14	Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тогтоолыг батлуулах	10 минут	Хурлын дарга

Хурлын үргэлжлэх хугацаа

2 цаг 30 минут

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн
5 тоот тогтоолын Хавсралт №3



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС №1

Компанийн оноосон нэр: ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК
Байршил: Танхимаар
Хурал хуралдах огноо: 2025 оны 4 сарын 30-ны өдөр 10:00 цагт

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:				
Итгэмжлэлийн дагуу төлөөлж байгаа төлөөлөгч этгээдийн тухай тайлбар:				
Регистрийн дугаар:				
Санал өгөх хувьцааны тоо:				
Утасны дугаар:				
Цахим хаяг:				
Хэлэлцэх асуудал		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;			
2	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;			
3	“Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ тогтоолыг танилцуулах;			
4	Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах;			
5	ТУЗ гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох тухай;			
6	Өрийн бичиг гаргах тухай хэлэлцэн батлах;			
7	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах;			
8	Компанийн шинэчилсэн дүрмийг батлах;			

Заавар: Та өөрийн саналыг (+) тэмдгээр бичнэ.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг : /
Тооллогын комисс бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм ☐ Үгүй ☐
Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн
5 тоот тогтоолын Хавсралт №4



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС №2

Компанийн оноосон нэр: ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК

Байршил: Танхимаар

Хурал хуралдах огноо: 2025 оны 4 сарын 30-ны өдөр 10:00 цагт

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:		
Итгэмжлэлийн дагуу төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар:		
Регистрийн дугаар:		
Санал өгөх хувьцааны тоо:		
Кумулятив аргаар санал өгөх тоо:		
Гэрийн хаяг:		
Утасны дугаар:		
Цахим хаяг:		
Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч		Нэр дэвшигчид өгөх саналын тоо/кумулятив аргаар/
1		
2		
3		
4		
5		
6		
Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч		
1		
2		
3		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, нэр: /

Комиссын даргын гарын үсэг нэр: /

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм Үгүй

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:

.....

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн
5 тоот тогтоолын Хавсралт №5



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Хурлын төрөл:	Ээлжит
Хурал хуралдах өдөр, цаг:	2025 оны 4 сарын 30 өдөр 10:00 цагт
Хурал хуралдах газар	УБ, БГД, 2-р хоро, Эрхи төв, 402 тоот
Бүртгэлийн өдөр:	2025 оны 4 сарын 10 өдөр
Хэлэлцэх асуудал:	1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах; 2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах; 3. “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ тогтоолыг танилцуулах; 4. Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах; 5. ТУЗ гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох тухай; 6. Өрийн бичиг гаргах тухай хэлэлцэн батлах; 7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах; 8. Компанийн шинэчилсэн дүрмийг батлах; 9. Бусад
Баримт бичигтэй танилцах:	2025 оны 4 сарын 24 өдрөөс 2025 оны 4 сарын 29 өдрийн 17:00 цаг хүртэл
Холбоо барих:	info@vik.mn tandeminvest.nbfi@gmail.com 88008702, 70151510



**ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн
хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дах заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ



**ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дах заалт болон Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №1-р баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 30 өдөр
хот

Дугаар 03

Улаанбаатар

Компанийн дүрмийн сан нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.2.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 70 тоот тогтоол, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2025 оны жилийн эцсийн аудитлагдсан тайланд тусгагдсан хуримтлагдсан ашгаас 1,440,000,000 */нэг тэрбум дөрвөн зуун дөчин сая/* төгрөгөөр нэмэгдүүлж, компанийн энгийн хувьцааны нэрлэсэн үнийг 3.02 */гурван төгрөг хоёр мөнгө/* болгон нэмэгдүүлсүгэй.
2. Компанийн дүрмийн сангийн тооцооллыг Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хийгдэх өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолын Хавсралт №1

ДҮРМИЙН САНГИЙН ТООЦООЛОЛ

Тайлбар	Одоо	Шинэчилсэн
Дүрмийн сан	4,600,000,000	6,040,000,000
Хувьцааны тоо	2,000,000,000	2,000,000,000
Хувьцааны нэрлэсэн үнэ	2 төгрөг 30 мөнгө	3 төгрөг 2 мөнгө



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 30 өдөр
хот

Дугаар 04

Улаанбаатар

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнээр сонгосугай.

1.1 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

Ч.Чинзориг
Ч.Бадмаараг
Л.Очирмаа
Ц.Билэг-Өрнөх
Ч.Тэмүдэр
П.Чинзориг

1.2 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

А.Даваазориг
Ч.Лодойравсал
Б.Энх-Амгалан

2. Компанийн үр ашигтай ажиллагааг удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 30 өдөр
хот

Дугаар 05

Улаанбаатар

Өрийн бичиг гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 42 дугаар зүйлийн 42.1, 62 дугаар зүйлийн 62.1.15 дах заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх зорилгоор өрийн бичгийг нээлттэй болон хаалтай хэлбэрээр, зохих хууль журмыг баримтлан гаргах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ



**ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 сарын 30 өдөр
хот

Дугаар 08

Улаанбаатар

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг Хавсралт №1-р баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороонд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн
ХЭ-ийн ээлжит хурлын 08 тоот тогтоолын Хавсралт №1

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөв

№	Зардлын төрөл	Тоо	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Цалин /дарга/	1	1,500,000	18,000,000
2	Цалин /гишүүд/	8	1,000,000	96,000,000
3	Цалин/ нарийн бичгийн дарга/	1	900,000	10,800,000
4	ТУЗ ээлжит хурлын зардал	4	2,000,000	8,000,000
5	ТУЗ ээлжит бус хурлын зардал	6	1,500,000	9,000,000
6	ТУЗ-н бичиг хэрэг			10,000,000
7	ТУЗ-ын томилолт			50,000,000
Нийт дүн				201,800,000



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 30 өдөр
хот

Дугаар 09

Улаанбаатар

Компанийн шинэчилсэн дүрмийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Тандэм Инвэст ХК-ийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.
3. Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 09 тоот тогтоолын Хавсралт №1

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн дүрэмд орох өөрчлөлтүүд:

Харьцуулалтууд								
Хуучин				Шинэчилсэн				Тэмдэглэл
6.1.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 4,600,000,000 /Дөрвөн тэрбум зургаан зуун сая зургаан зуун төгрөг/ төгрөг байна.				6.1.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 6,040,000,000 /зургаан тэрбум дөчин сая/ төгрөг байна.				Шинэчилсэн
6.2				6.2				
Компанийн хувьцаа	Тоо ширхэг		Хувьцааны төрөл	Компанийн хувьцаа	Тоо ширхэг		Хувьцааны төрөл	
Зарласан хувьцаа	Нийт 6,003,866,050 ширхэг	Энгийн эрхийн 5,000,000,000 ширхэг	Энгийн эрхийн	Зарласан хувьцаа	Нийт 6,003,866,050 ширхэг	Энгийн эрхийн 5,000,000,000 ширхэг	Энгийн эрхийн	
		Давуу эрхийн 1,003,866,050 ширхэг	Давуу эрхийн			Давуу эрхийн 1,003,866,050 ширхэг	Давуу эрхийн	
Гаргасан хувьцаа	Нийт 2,000,000,000 ширхэг		Энгийн эрхийн	Гаргасан хувьцаа	Нийт 2,000,000,000 ширхэг		Энгийн эрхийн	
6.2.2 Компани нэг бүр нь 2.3 /хоёр төгрөг гучин мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,000,000,000 /Хоёр тэрбум / ширхэг гаргасан энгийн хувьцаатай байна.				6.2.2 Компани нэг бүр нь 3.02 /гурван төгрөг хоёр мөнгө/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,000,000,000 /Хоёр тэрбум / ширхэг гаргасан энгийн хувьцаатай байна.				Шинэчилсэн